



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХӨДӨӨ, АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН 91.0 ХУВИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАЖ БАЙНА.

Тайланг хүргүүлсэн этгээд: Дорнод аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга, Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хэрлэн, Баян-Уул, Булган, Гурванзагал, Сэргэлэн, Халхгол, Дашбалбар сумдын Засаг дарга нарт болон Үндэсний аудитын газар

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер И.Сэмжидмаа Утас: 7058-4207,

Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Батжаргал Утас: 7058-4207,

Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn

Аудитор М.Ухаанбилэг, М.Ганбилэг Утас: 7058-4207,

Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn ganbilegm@audit.gov.mn

Чойбалсан хот 2023 он

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ: “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. *Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх;*
2. *Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх;*
3. *Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх;*

Аудитын гол үр дүн: ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН 91.0 ХУВИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАЖ БАЙНА.

- **А. ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨДӨӨ, АЖ АХУЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДСАН БАЙНА.**

А.1 ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨДӨӨ, АЖ АХУЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДСАН БАЙНА.

А.1.1. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцсэн төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулсан байна.

А.1.2. Төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээнд зээл олгосон байна.

А.2 ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ХӨРӨНГҮҮДИЙН 9.0 ХУВЬ АШИГЛАЛТГҮЙ БАЙНА.

А.2.1. Зээлийн хөрөнгийг ашиглагч гэрээнд заасан үүргээ тогтоосон хугацаанд биелүүлж ажилласан байна.

А.2.2. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийн 9.0 хувь ашиглалтгүй байна.

- **Б. ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН 91 ХУВИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАЖ БАЙНА.**

Б.1 ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ГЭРЭЭНД ТУСГАСАН ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ НЬ САЛБАРЫН БОДЛОГОТОЙ УЯЛДСАН БАЙНА.

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Б.1.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогыг дэмжсэн байна.

Б.1.2 Төслийн хөрөнгө оруулалтаар Дашбалбар, Баян-Уул сумдад хийгдсэн ЖДҮ-ийг дэмжих төв иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.

Б.1.3 Төсөл хэрэгжүүлсний дараах ашиглалттай холбоотой асуудлыг тооцож төлөвлөхгүй байна.

Б.2 АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН 9 ТӨСӨЛ ИРГЭДЭД ҮР ӨГӨӨЖӨӨ ӨГӨӨГҮЙ БАЙНА.

Б.2.1 Аймгийн Засаг дарга ХХААХҮЯ-ны сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан төслийн хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлж ажилласан байна.

Б.2.2 Ажлын байрыг дэмжих чиглэлээр хийгдсэн 9 төсөл иргэдэд үр өгөөжөө өгч эхлээгүй байна.

- **В. ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД БҮРЭН ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**

В.1 АРИЛЖААНЫ БАНКААР ДАМЖИЖ ОЛГОГДСОН ЗЭЭЛИЙН ҮР ДҮНД ТӨСЛИЙН НЭГЖЭЭС ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

В.1.1 Зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

В.1.2 Арилжааны банкаар дамжиж олгогдсон зээлийн үр дүнд төслийн нэгжээс тавих хяналт хангалтгүй байна.

В.2 БЕЛАРУСЬ УЛСЫН ЗГ-ЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛЭЭР 2021 ОНД ИРГЭН, ААН-ДЭД ОЛГОСОН ТРАКТОР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.

В.2.1 “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилт төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна.

В.2.2 Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг санхүүгийн бүртгэлд тусгаж, тайлагнасан байна.

ДҮГНЭЛТ: Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан байна.

2. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн 91 хувийг үр дүнтэй ашиглаж байна.

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

3. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ гэрээнд тусгасан төслийн зорилго, зорилт нь салбарын бодлоготой уялдсан байна.
4. Төслийн хөрөнгө оруулалтаар Дашбалбар, Баян-Уул сумдад хийгдсэн ЖДҮ-ийг дэмжих төв иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.
5. Төсөл хэрэгжүүлсний дараах ашиглалттай холбоотой асуудлыг тооцож төлөвлөхгүй байна.
6. Ажлын байрыг дэмжих чиглэлээр хийгдсэн 9 төсөл иргэдэд үр өгөөж өгөөгүй байна.
7. Аймгийн Засаг дарга нь ХХААХҮЯ-ны Сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан төслийн хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлж ажилласан байна.
8. Арилжааны банкаар дамжиж олгогдсон зээлийн үр дүнд төслийн нэгжээс тавих хяналт хангалтгүй байна.
9. Беларусь Улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлээр 2021 онд иргэн, аж ахуй нэгжүүдэд олгосон трактор, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.
10. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилт төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна.
11. Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг санхүүгийн бүртгэлд тусгаж, тайлагнасан байна.

Аудитаар нийт 793.4 сая төгрөгийн алдаа, зөрчилтэй асуудал илэрсэнд холбогдох байгууллага албан тушаалтанд 6.0 сая төгрөгийн төлбөрийн акт 1, хариуцлага тооцуулах албан шаардлага 1, зөрчил арилгуулах 787.4 сая төгрөгийн албан шаардлага 7, зөвлөмж 2 өгсөн. Мөн нэгдсэн тайланд тусгуулах 2 саналыг боловсруулсан.

САНАЛ: ҮАГ-ын нэгдсэн тайланд тусгуулах санал.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд:

1. Арилжааны банкаар дамжиж олгогдсон төслийн зээлийн үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж байх.
2. Беларусь Улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлээр олгосон трактор, тоног төхөөрөмжийн ашиглалт, төслийн үр дүнд журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

1. Төслийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хөрөнгийг хариуцан авч явах эзэмшигч, мөн ашиглалтыг тооцож төлөвлөж байх.

Дорнод аймгийн ХХААГ-т:

2. Иргэд олон нийтийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцон төслийн хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөж байх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.